



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 418

Улаанбаатар хот

Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Тэнгэр даатгал” ХХК-ийн “Тусгай зориулалтын машин механизмын даатгал” бүтээгдэхүүнийг шинэчлэн нэгдүгээр хавсралтаар, “Хүнд даацын тээврийн хэрэгслийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг шинээр хоёрдугаар хавсралтаар тус тус бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Тэнгэр даатгал” ХХК /Ойбек Н.Халилов/-д үүрэг болгосугай.

3. Хавсралтад дурдсан бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Тэнгэр даатгал” ХХК /Ойбек Н.Халилов/-д анхааруулсугай.


4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН


Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 12-р сарын 27-ны өдрийн
41.2 – р тогтоолын нэгдүгээр хавсралт



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Тэнгэр даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Тусгай зориулалтын машин механизмын даатгал”,
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Авто тээврийн хэрэгслийн даатгал
4.	Даатгалын зүйл	Тусгай зориулалтын машин механизмын даатгал”-ын бүтээгдэхүүний хувьд: Даатгалын гэрээ болон даатгалын баталгаанд бичигдсэн, авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгэлтэй М ангиллын тусгай зориулалтын машин механизм;
5.	Даатгалын эрсдэл	Даатгалын зүйлд хохирол учруулж болох ерөнхий болон дэд гэрээнд заасан нөхцөл, орчин
6.	Даатгалын гэрээний хугацаа	1 жил
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	Ерөнхий гэрээ нь 7 бүлэг, 88 заалт, дэд гэрээ нь 14 зүйл, 2 хавсралаас бүрдэж байна.
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Гүйцэтгэх захирлын 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А/24 тоот тушаал
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Б.Даваасүрэн
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Андеррайтинг хариуцсан захирал Б.Заяа, Маркетинг, бизнес хөгжлийн хэлтэс М.Туул, Б.Мөрөн

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 22-р сарын 27-ны өдрийн
428-р тогтоолын хоёрдугаар хавсралт



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Тэнгэр даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	“Хүнд даацын тээврийн хэрэгслийн даатгал”
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Авто тээврийн хэрэгслийн даатгал
4.	Даатгалын зүйл	“Хүнд даацын тээврийн хэрэгслийн даатгал”-ын бүтээгдэхүүний хувьд: Даатгалын гэрээ болон даатгалын баталгаанд бичигдсэн, авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгэлтэй, хүн ба ачаа тээвэрлэхэд зориулсан С /СЕ болон D/ DE ангиллын өөрөө явагч механикжсан тээврийн хэрэгсэл;
5.	Даатгалын эрсдэл	Даатгалын зүйлд хохирол учруулж болох ерөнхий болон дэд гэрээнд заасан нөхцөл, орчин
6.	Даатгалын гэрээний хугацаа	1 жил
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	Ерөнхий гэрээ нь 7 бүлэг, 129 заалт, дэд гэрээ нь 14 зүйл, 2 хавсралаас бүрдэж байна.
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Гүйцэтгэх захирлын 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А/24 тоот тушаал
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Б.Даваасүрэн
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Андеррайтинг хариуцсан захирал Б.Заяа, Маркетинг, бизнес хөгжлийн хэлтэс М.Туул, Б.Мөрөн